



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гадаадын иргэн, харьяатын газрын хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах журам”-ыг хавсралтаар шинэчлэн дагаж мөрдсүгэй.

2.Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай

3.Шинэчлэн батлагдсан Гадаадын иргэн, харьяатын газрын хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах журам”-ыг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын “Журам батлах тухай” 2019 оны А/199 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

17220051-

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны
өдрийн 1784 дугаар тушаалын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН
ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ
ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяатын газар (цаашид "Байгууллага" гэх)-ын хариуцлагатай эргүүл, жижүүр нь үүрэг гүйцэтгэж байх үедээ гадаадын иргэдэд зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах, байгууллагын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. "объект" гэж төв, орон нутагт албаны үйл ажиллагаа явагдаж байгаа барилга байгууламжийг;

1.2.2. "хариуцлагатай эргүүл" гэж хариуцлагатай жижүүрийн үйл ажиллагааг мэргэшил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг;

1.2.3. "хариуцлагатай жижүүр" гэж гадаадын иргэдэд зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээг үзүүлэх, объектыг гаднын нөлөө, болзошгүй аюул, гэмт халдлагаас хамгаалах, объектод нэвтэрч байгаа албан хаагч, үйлчлүүлэгч, зочны хөдөлгөөнд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг;

1.2.4. "үйлчлүүлэгч" гэж тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхээр болон үйлчилгээ авах зорилгоор төв байрны үйлчилгээний заал, объектод нэвтрэх иргэн, хуулийн этгээдийн төлөөллийг;

1.2.5. "зочин" гэж үйлчилгээ авахаас бусад зорилгоор объектод нэвтрэх иргэнийг;

Хоёр. Хариуцлагатай эргүүл, жижүүр ажиллах зарчим

2.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.4, 98 дугаар зүйлийн 98.1-д зааснаар нийтээр амрах баярын болон тэмдэглэлт өдрүүд, бусад шаардлагатай үед хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах ажилтныг байгууллагын даргын тушаалаар томилон ажиллуулна. Хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах хуваарийг Захиргаа, удирдлагын газар гаргаж байгууллагын даргаар батлуулна.

2.2. Албан тушаалын ТҮ-3-аас доош ангилал, зэрэглэлд хамаарах албан тушаалтан хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэхгүй.

2.3. Хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэхээр томилогдсон албан хаагч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд харьяа нэгжийн дарга дотооддоо зохицуулалт хийж өөр албан хаагчаар үүрэг гүйцэтгүүлж болно.

2.4. Хариуцлагатай эргүүл нь хариуцлагатай жижүүрээр томилогдсон албан тушаалтныг удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллана.

2.5. Хариуцлагатай жижүүр нь гадаадын иргэнд зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд орон нутаг дахь газар, хэлтсийн хариуцлагатай эргүүл, жижүүрээс нөхцөл байдлын мэдээг шаардлагатай тохиолдолд 09, 14, 19 цагт авна.

2.6. Төв байранд үүрэг гүйцэтгэсэн хариуцлагатай эргүүл, жижүүр нь ажилласан

хугацааны болон орон нутаг дахь газрын хариуцлагатай эргүүл, жижүүрээс авсан нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг нэгтгэн, танилцуулга бичиж, дараагийн ээлжид гарах жижүүрт 08 цагт хүлээлгэн өгнө. Шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдлагад тухай бүр шуурхай танилцуулна.

2.7. Хариуцлагатай жижүүрээр ажилласан ажилтныг нөхөн амруулах асуудлыг харьяалах нэгжийн дарга шийдвэрлэнэ.

Гурав. Хариуцлагатай жижүүрийн эрх

3.1. Объектод нэвтрэх үйлчлүүлэгч, зочинд хууль ёсны шаардлага тавих эрхтэй.

3.2. Байгууллагын барилга байгууламжийн аюулгүй байдал, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад эрсдэл учруулахуйц нөхцөл байдлын (хаалга, цонх, цоож гэх мэт) талаар Захиргаа, удирдлагын газрын, орон нутагт газар, хэлтсийн дарга нарт мэдэгдэж шуурхай арга хэмжээ авч шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Хариуцлагатай жижүүрийн үүрэг

4.1. Үүрэг гүйцэтгэж байх үедээ гадаадын иргэнд зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээг үзүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, барилга байгууламжийн аюулгүй байдал, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах ба сэжигтэй байдал илэрвэл харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй харуул, жижүүр болон харьяалах нэгжийн даргад нэн даруй мэдэгдэж, таслан зогсоох арга хэмжээ авна.

4.2. Үйлчлүүлэхээр ирсэн үйлчлүүлэгч болон зочинтой ажил, үйлчилгээний стандартын дагуу харилцана.

4.3. Объектын хариуцлагатай жижүүр нь үүрэг гүйцэтгэх явцад анхаарал татсан хөдөлгөөн, зөрчил болон бусад тэмдэглэвэл зохих зүйлийн талаарх танилцуулгадаа цаг хугацааг тодорхой, үгийг товчлохгүйгээр, гаргацтай, дэлгэрэнгүй бичнэ.

Тав. Гэнэтийн осол, аюулын үед авах арга хэмжээ

5.1. Хариуцлагатай жижүүр нь гал түймэр, газар хөдлөлт, аваар осол, ус цахилгаанаас үүдэн гарах гэнэтийн болон бусад аюултай нөхцөл байдал бий болсон үед харьяалах нэгжийн дарга, аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн болон харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй харуулд нэн даруй холбогдох байгууллагад (онцгой байдал, цагдаа гэх мэт) яаралтай мэдэгдэж зохих арга хэмжээг авна.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Хариуцлагатай жижүүр нь үүрэг гүйцэтгэж байхдаа бусдыг үл хүндэтгэх, зүй бус авир гаргах, дур мэдэн орхиж явах, харьяалах нэгжийн даргын зөвшөөрөлгүйгээр бусад албан хаагчийг орлуулан үлдээх зэрэг үйлдэл гаргахыг хориглоно.

Долоо. Хариуцлага

7.1. Батлагдсан хуваарийн дагуу үүрэг гүйцэтгээгүй хариуцлагатай эргүүл, жижүүрт холбогдох хууль, журамд заасан үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулна.

--- оОо ---

